



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

### “Соёмбо даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам, заавар”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Соёмбо даатгал” ХХК-ийн нийт 5 000 000 ширхэг хувьцааг тус компанийн хувьцаа эзэмшигч болох Ч.Батцогт, Ч.Сайнзаяа, Ц.Баттулга нар “Бишрэлт холдинг” ХХК-нд худалдах, худалдан авах гэрээгээр худалдахыг зөвшөөрч, “Соёмбо даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийг хавсралтад дурдсанаар өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгагч болон даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Соёмбо даатгал” ХХК /Ц.Баттулга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД

Санхүүгийн зохицуулах хорооны  
2016 оны 05 дугаар сарын 07 өдрийн  
152 тоот тогтоолын хавсралт



“Соёмбо даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Дүрмийн сангийн (хувь нийлүүлсэн хөрөнгийн) хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-д эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1.	Чимидийн Сайнзаяа	1,427,100,000	-1,427,100,000	00.00	00.00
2.	Чимидийн Батцогт	2,911,450,000	-2,911,450,000	00.00	00.00
3.	Цэрэнчанаагийн Баттулга	661,450,000	-661,450,000	00.00	00.00
4.	“Бишрэлт холдинг” ХХК	-	5,000,000,000	5,000,000,000	100.00
	Нийт	5,000,000,000	5,000,000,000	5,000 000,000	100.00

---ooOoo---